

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр, Пүрэв гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-18

<i>1. “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	6-9
<i>2. “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	9-13
<i>3. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг</i>	13-17
<i>4. Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	17-18

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
03 дугаар сарын 16-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 23 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Булгантуяа;

Чөлөөтэй: Н.Энхболд;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Т.Аюурсайхан, Б.Бат-Эрдэнэ;

Тасалсан: Д.Бат-Эрдэнэ, Д.Ганбат.

Нэг. “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, мөн газрын Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Г.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баделханы тавьсан асуултад Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа нар хариулж, тайлбар хийв.

Б.Энх-Амгалан: “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, мөн газрын Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Г.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн, Г.Амартүвшин нарын тавьсан асуултад Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа нар хариулж, тайлбар хийв.

Б.Энх-Амгалан: “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 11
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, мөн газрын Хуулийн бодлогын газрын дарга О.Машбат, Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар танилцуулав.

Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн тавьсан асуултад Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар хариулж, тайлбар хийв.

Б.Энх-Амгалан: Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан “Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энх-Амгалан: “Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 48 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 11 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжисин Д.Сүхбаатар”
танхим
14 цаг 23 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энх-Амгалан: Гишүүдийн ирцийг танилцуулъя. Энх-Амгалан гишүүн ирсэн, Алтанхуяг гишүүн өвчтэй, Амартүвшин гишүүн ирсэн, Анужсин гишүүн ирсэн, Аюурсайхан гишүүн өвчтэй, Бат-Амгалан гишүүн ирсэн, Баттөмөр гишүүнийг хуралдаа ир гэж хэлье. Баделхан гишүүн ирсэн, С.Батболд гишүүн ирсэн, Б.Бат-Эрдэнэ гишүүн өвчтэй, Д.Бат-Эрдэнэ гишүүнийг дуудъя. Булгантуяа гишүүн орон нутагт томилолттой. Ганбат гишүүнийг хуралдаа дуудъя. Доржханд гишүүн алга байна, Доржханд гишүүн рүү яриарай. Дэлгэрсайхан гишүүн ирсэн. Наранбаатар гишүүн алга байна, яриарай. Сэргэлэн гишүүн ирсэн, Цогтбаатар гишүүн ирсэн, Нямаагийн Энхболд гишүүн чөлөөтэй. Ирээгүй гишүүд хуралдаа ирье. Баттөмөр гишүүн рүү яриарай. Д.Бат-Эрдэнэ гишүүн рүү яриарай, Ганбат гишүүн рүү яриарай, Доржханд гишүүн рүү яриарай, Наранбаатар гишүүн рүү яриарай.

Ажлын хэсгийнхэн гишүүддээ бас хэлээрэй. Яагаад гэвэл хэлэлцэж байгаа 4 асуудал дөрвүүлээ санал хураалттай. Тийм учраас гишүүдийг хуралдаандаа идэвхтэй оролцоод, яг хуралдааны юманд санал хураалтад оролцох юм шүү гэдгийг нь бас ажлын хэсгийнхэн сануулаадахъя. Одоо нэг гишүүн. Баттөмөр гишүүн ирсэн байна. Доржханд гишүүн рүү ярья. Наранбаатар гишүүн рүү ярья. Ганбат гишүүн хуралдаа ирье. Д.Бат-Эрдэнэ

гишүүн хуралдаа ирье. Хэлэлцэх асуудалтай холбоотой ажлын хэсгийн гишүүдийг байлгаарай.

Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу өнөөдрийн хуралдааны ирцийг танилцуулъя. Өнөөдрийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд Б.Энх-Амгалан гишүүн ирсэн байна. Алтанхуяг гишүүн өвчтэй байна, Г.Амартүвшин гишүүн ирсэн байна. Анужсин гишүүн ирсэн байна. Аюурсайхан гишүүн өвчтэй байна. Э.Бат-Амгалан гишүүн ирсэн байна. Б.Баттөмөр гишүүн ирсэн байна. Х.Баделхан гишүүн ирсэн байна. С.Батболд гишүүн ирсэн байна. Б.Бат-Эрдэнэ гишүүн өвчтэй байна. Д.Бат-Эрдэнэ гишүүн ирээгүй байна. Х.Булгантуяа гишүүн орон нутагт томилолттой байна. Д.Ганбат гишүүн ирээгүй байна. Т.Доржханд гишүүн ирсэн байна. Б.Дэлгэрсайхан гишүүн ирсэн байна. Н.Наранбаатар гишүүн ирээгүй байна. Ц.Сэргэлэн гишүүн ирсэн байна. Д.Цогтбаатар гишүүн ирсэн байна. Н.Энхболд гишүүн чөлөөтэй байна. Гишүүдийн ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдааны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын тавьдугаар зүйлийн А хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулах тухай Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2023 оны 1 сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах. 2.Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2023 оны 1 сарын 10-ны

өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах. 3.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023 оны 1 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх. 4.Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар тухай Байнгын хорооны тогтоолын төсөл. Ийм эдгээр асуудлуудыг хэлэлцэхээр товлосон байна.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Алга байна. Тэгвэл хэлэлцэх асуудалдаа оръё. Өмнө нь бас хэлэлцэж байсан юмнууд байгаа юм энэ.

Нэг. “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн А хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор ажлын хэсгийг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн Сандагийн Бямбацогт Зам, тээврийн хөгжлийн сайд. Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга Сүхээгийн Мяндасмаа, 5 номерын микрофон дээр суугаарай. Иргэний

нисэхийн ерөнхий газрын дарга Чимэддоржийн Мөнхтуяа 4 номер дээр суучхаарай. Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Гүррагчаагийн Батбаяр 5 дээр сууших. Эдгээр хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Байнгын хорооны гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Монгол Улс Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц 1989 онд нэгдэн орсон. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 162 дахь гишүүн болсноор энэ байгууллагын бодлого, стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, гэрээ конвенцод нэгдэх, аюулгүй ажиллагааны аудитад хамрагдах зэргээр гишүүний үүргээ биелүүлж, олон улсад агаарын тээвэр, агаарын навигацийн үйл ажиллагааг өргөжүүлсээр ирсэн. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 2016 оны 39 дэх ассамблей чуулганаар Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн А хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах протоколыг баталж, зөвлөлийн гишүүн 36 орныг 40 болгон нэмэгдүүлэхээр шийдсэн байдаг.

Зөвлөлийн гишүүн улсуудыг агаарын тээврийн салбарт тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг, агаарын навигацид их хувь нэмэр оруулдаг, газар зүйн голлох бүс нутгийн төлөөлөл гэсэн 3 ангиллаар ассамблейгаас 3 жилийн хугацаанд сонгодог. Протокол нь нийт 128 улс нэгдсэнээр хүчин төгөлдөр болох бөгөөд одоогийн байдлаар 80 улс нэгдэж соёрхон батлаад байгаа. Монгол Улс багтдаг Ази Номхон далайн бүсээс 7 улс буюу Австрали, Хятад, Япон, Энэтхэг, Сингапур, Малайз, Өмнөд Солонгос улс

зөвлөлийн гишүүнээр одоо 2022 онд сонгогдсон байгаа. Монгол Улс энэхүү протоколыг соёрхон баталснаар зөвлөлийн гишүүдийн тоог нэмэгдүүлэх олон улсын санаачилгад хувь нэмрээ оруулж, цаашид олон улсын иргэн нисэхийн байгууллагын бодлого тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд оролцох, Зөвлөлийн гишүүнээр сонгогдоход дэмжлэг болох юм. Протоколыг соёрхон баталснаар улсын төсвөөс нэмэлт зардал гарахгүй. Шинээр хууль боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шаардлага үүсэхгүй юм. Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Бямбацогт сайдад баярлалаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү. Баделхан гишүүнээр тасаллаа. Баделхан гишүүн асуулт асууя.

Х.Баделхан: Баярлалаа. Хуулийн төслийг дэмжиж байгаа. Энэ иргэний нисэхийн салбартай холбоотой 2 асуулт асуучихмаар байна. Нэгдүгээрт бол энэ баруун аймгуудад бол тийзийн үнэ бол хэт өндөр байна. Энэ олон удаа яригдаж байгаа. Бид нар сая хөдөө яваад ирсэн иргэд ч ярьж байна. Ер нь онгоцоор хүн зорчих боломжгүй болсон байна. Хэт өндөр үнэтэй учраас. Сая ерөөсөө явж ирж байгаа онгоц нь бол ер нь нэг хэдхэн хүнтэй л явж байна. Ер нь цаашидаа ийм байдлаар явж болохгүй шүү дээ. Тийм учраас энэ дээр ер нь ямар арга хэмжээ авах гэж байгаа юм бэ? Энийг хямдруулж болох уу? Ер нь хямдруулахгүй бол ийм байдлаар тэр нисэх онгоц явах боломжгүй л дээ.

Хоёр дахь нь бол манай аймагт дээр нэг тэр нөгөө нисэхийн барилгын өргөтгөл бид нар өнгөрсөн жил улсын төсөвт оруулсан. Тэгээд өнгөрсөн жил

эзэн нь шалгараагүй, тэгээд барилга нь баригдаагүй. Энэ жил дахиад бид нар оруулсан, гишүүдийн зүгээс санаачлаад оруулж байгаа. Одоо ингээд 4 сар дууслаа. Компани шалгараагүй эзэнгүй бараг оны тал нь өнгөрч байгаа шүү дээ. Өдийд уг нь өнгөрсөн жил улсын төсөвт орсон барилга, одоо энэ жил дахиад бид нар батлуулж өгсөн. Тэр дахиад зураг төсвийн магадлан хийлгээд. Одоог хүртэл компани шалгараагүй. Одоо бол жинхэнэ ажлаа эхэлж байх ёстой шүү дээ. Энэ яагаад ингээд удааж байгаа юм бэ? Энэ талаар нэг хариу өгөөч гэсэн 2 асуулт байна.

Б.Энх-Амгалан: Шууд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуудал биш ч гэсэн зам, тээврийн салбартай холбоотой асуудал байгаа учраас Бямбацогт сайд тодорхой товчхон хариулчих. Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Баделхан гишүүний асуултад хариулъя. Тэгээд орон нутгийн нислэгийг сэргээх талаар бас Монгол Улсын Засгийн газар, Зам, тээврийн хөгжлийн яам бас нэлээд одоо идэвх чармайлт гаргаад ажиллаж байгаа. Ер нь агаарын тээврийн либералчлалыг бас хийх, Шинэ сэргэлтийн бодлогод тусгасан зорилтуудыг одоо хангах талаар бас тодорхой үр дүн гарч байгаа. Олон улсын нислэгүүд нэлээн сэргэсэн. Мөн олон улсад бас нислэгийн үнэ тийз буурсан. Олон чиглэлд одоо бас Монгол Улсын иргэд маань хямд тийзээр нисэх бололцоо боломж бүрдсэн. Ийм үр дүн гарч байгаа.

Нөгөө талдаа бас орон нутгийн нислэгээ сэргээх тал дээр тодорхой үр дүн гаргах гээд одоо ажиллаж байгаа. Улсын Их Хурлын тогтоолоор ч гэсэн бас Засгийн газарт үүрэг өгсөн байгаа. Орон нутгийн нислэгийг сэргээх арга хэмжээ авна шүү гэж. Энэ одоо бас Улсын Их Хурлаас өгсөн үүргийг биелүүлэх тал дээр бас Засгийн газар, Зам, тээврийн

хөгжлийн яам ажиллаж байна. Нэлээн одоо төвөгтэй байгаа. Бензин, шатахууны үнэ өндөр байна. Бензин, шатахууны онгоцны түлшний үнийг бас бууруулах талаар тодорхой арга хэмжээ авахаар ажиллаж байна. Нэмэгдсэн өртгийн албан татвар, төмөр замын салбарт авдаггүй. Нийтийн тээвэрт авдаггүй мөртөө зөвхөн агаарын тээвэрт авч байгаа энэ НӨАТ-ыг одоо бас НӨАТ-гүй болгох асуудал нэмэгдсэн өртгийн албан татваргүй олгох асуудлыг бид анхаарч, холбогдох хуулийн төслийг боловсруулахаар Сангийн яамтай бас ярилцаж байгаа.

Мөн авиа компаниудыг бас нислэгүүдийг нэмэгдүүлээч гэсэн шаардлагад ялангуяа үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ компани дээр бид нар бас тодорхой үүрэг даалгавар өгсөн. Орон нутгийн нислэг сэргээх чиглэлээр тодорхой онгоц оруулж ирье. Хувийн компаниудыг бид нар бас тодорхой шахахад хэцүү байна, зах зээлийн зарчмаар ажиллаж байгаа учраас. Тийм болохоор одоо энд бас нэг үүргээ ТӨК-аас бас үүргээ биелүүлээч гэсэн ийм бас үүрэг чиглэл өгсөн байгаа. Үүнээс гадна бас ер нь одоо Оюу толгойн нисэх чиглэлд маш их нисэж байгаа. Оюу толгой руу жилдээ 300000 зорчигч нисдэг, өндөр үнэтэй нисдэг. Эндээс одоо хангалттай ашиг олчихдог. Орон нутгийн нислэг дээр одоо бусад аймгууд руу болохоор дөнгөж нэг 35000 иргэн нисэж байгаа. Энийг бол одоо бас нэг тийм зөнгөөр нь хаячхаад байгаа учраас бас одоо нийгмийн хариуцлагаа хүлээ, ашигтай нислэгтэй чиглэлдээ нисдэг, ашиггүй чиглэлдээ нисдэггүй ийм байж болохгүй энд бас тооцоо судалгаанууд хийгдэж байна. Ингэж одоо бас авиа компаниуддаа тодорхой үүрэг өгөхөөр бас ажиллаж байгаа.

Гэхдээ зах зээлийн зарчмаар явах учир бид нар шахаж чадахгүй байгаа. Одоо эцсийн нэг арга бол бид тодорхой хэмжээгээр бас төрөөс бас дэмжлэг үзүүлэх, богино хугацаанд унасан, юу

ковидын үед унасан салбараа хөл дээр нь босгоход хөл дээрээ нэг тогтчих юм бол энэ цаашаа аяндаа алхаад явчих байх. Хөл дээр нь босгоод нэг тогтоогоод, алхтал нь тодорхой дэмжлэг бас Засгийн газраас төрөөс бас үзүүлэхгүй бол яг одоогоор бол хүнд байдалтай байгаа. Яах аргагүй алслагдсан. Ер нь одоо бол зөвхөн Ховд, Баян-Өлгий гэсэн хоёрхон аймагт хуваарьтай нислэг хийж байгаа. Бусад аймгууд руу бол захиалгатай чартер нислэг хийж байгаа, бараг нислэггүй байгаад байгаа юм.

Гэтэл Монголд зочлох жил болгоод бид нар зарлачихсан байдаг. Гаднын одоо иргэд Монголд маш олон их хэмжээгээр ирнэ. Ирэнгүүтээ одоо Дорнод руу, Говь-Алтай руу, Баянхонгор руу нисэх шаардлага гараад онгоц байхгүй Хөвсгөл рүү. Орон нутгийн иргэд өвчтэй зовлонтой хүмүүс онгоцоор нисдэг, настай одоо хөгшин хөвөө хүмүүс нисдэг. Дээрээс нь нялх нойтон хүүхэдтэй, дөнгөж төрсөн эхчүүд нисдэг гээд энэ хүмүүс хамгийн нийгмийн эмзэг бүлгийнхэнд л энэ онгоцондоо хүрч байгаа юм л даа. Гэтэл онгоц байхгүй одоо тэгээд машинаар явж байгаа. Тийм болохоор энэ дээр бид нар бас анхаарал тавьж бас ер нь энэ оны эхний хагаст багтаагаад нэг тодорхой үр дүн гаргана гэсэн байдалтай нэлээд анхаарлаас гаргахгүй ажиллаж байгаа.

Баян-Өлгий аймгийн нисэх буудлын тухайд өнгөрсөн жил 2, 3 удаа тендер зарласан, бас тодорхой шалгуур шаардлага хангахгүй байна гэдэг асуудлаар бас энэ тендерүүд нь хүчингүй болсон байгаа. Энэ жил бол бас тендер зарлаад энэ ажлыг шалгаруулахаар бас манай Иргэний нисэхийн ерөнхий газар ажиллаж байх ёстой. Энэ дээр Мөнхтуяа дарга нэмээд хариулчих уу. Мөнхтуяа даргын микрофоныг өгчих үү.

Б.Энх-Амгалан: Нэмээд ажлын хэсгийн 4 номерын микрофоныг өгье.

Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Мөнхтуяа хариульъя.

Ч.Мөнхтуяа: Баян-Өлгийн нисэх онгоцны буудлын барилгын ажлыг Засгийн газрын нөөц сангаас нэг 500 саяар зураг төсөв хийлгэх ажил энэ одоо Баян-Өлгийн засаг иргэд Баян-Өлгий дээр өөр дээр нь явагдаж байгаа зураг төсвийн ажил. Яг барилгын нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилгын ажил нэг 4.5 тэрбум энэ жил төсөв нь овоо нэмэгдээд ороод ирсэн байж байгаа. Ноднин тендер шалгаруулалт 2.5 тэрбумын өртөгтэй байсан учраас үнийн дүнд нь хүрэхгүй шалтгаанаар тендер амжилтгүй болсон. Нэг компани санал өгсөн боловч тэр нь болоогүй юм. Энэ жил тендер шалгаруулалтыг энэ 4 сард багтааж дуусгахаар ажиллаж байна. Зам, тээврийн хөгжлийн яамнаас манай дээр эрх нь шилжээд ирчихсэн явж байгаа.

Б.Энх-Амгалан: Хариулт хангалттай юу? Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хэлэлцэж байгаа хуулийн төсөлтэй холбоо холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү. Алга байна. Одоо санал хураалт явуулья. Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн А хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулья. Гишүүд саналаа өгнө үү. Санал хураалт. Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар санал хураалт дэмжигдлээ. Бат-Амгалан гишүүний микрофон ажиллаагүй байгаа учраас, дэмжсэнээр протокол тэмдэглээрэй. Энэ асуудал дэмжигдлээ. Хуулийн төслийн хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан танилцуулья. Дараагийн асуудалд орёе.

14.37 цаг

Хоёр. “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсэг түрүүнийх хэвээрээ. Хэлэлцүүлж хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуулийн төслийн талаар талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Байнгын хорооны гишүүд ээ,

Олон улсын иргэний нисэхийн байгууллага нь агаарын тээврийн агаарын навигацийг өргөжүүлэх гишүүн улсуудын санаачилгыг дэмжиж 2016 оны 39 дүгээр ассамблейн чуулганаар Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг баталж, агаарын навигацийн комиссын гишүүний тоог 19 байсныг 21 болгон нэмэгдүүлсэн. Агаарын навигацийн комисс нь олон улсад агаарын навигацийг хөгжүүлэх бодлого тодорхойлох, мэдээлэл цуглуулах, стандарт, шаардлага тогтоох, зөвлөмж боловсруулах, техник, техник технологийн асуудлаар дэд комисс томилон ажиллуулах зэргээр олон улсын иргэний нисэхийн байгууллагын зөвлөлд зөвлөгөө өгөх үүрэгтэй байнгын ажиллагаатай комисс юм.

Уг комиссын бүрэлдэхүүнийг гишүүн улсаас нэр дэвшүүлсэн иргэний нисэхийн салбарын шинжлэх ухаан практик ажлыг зохих туршилагатай, мэргэжилтэй хүмүүсийн дотроос зөвлөл

сонгон шалгаруулж томилдог. Протокол нь гишүүн орны 2/3 буюу 128 улс нэгдсэнээр хүчин төгөлдөр болох үед одоогийн байдлаар 80 улс нэгдэн ороод байна. Монгол Улс энэхүү Протоколыг соёрхон баталснаар Агаарын навигацийн комиссын үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах, цаашид олон улсын иргэний нисэхийн байгууллагын агаарын навигацийг өргөжүүлэх, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд оролцох, мэргэшсэн хүний нөөцийг комиссын бүрэлдэхүүнд ажиллуулах боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ нутгийн агаарын навигацийн гол түшиц орон зай болох ОУНБ-ын ашиглалтыг сайжруулах, агаарын тээврийн өргөжин хөгжихөд дэмжлэг болно гэж үзэж байна. Протоколыг соёрхон баталснаар улсын төсвөөс нэмэлт зардал гарахгүй. Мөн одоо шинээр хуулийн төсөл боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шаардлагагүй. Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон баталж батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Бямбацогт сайдад баярлалаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Сэргэлэн гишүүнээр тасаллаа. Сэргэлэн гишүүн асуултаа асууя.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Яах вэ ерөнхийдөө хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоогүй боловч хэлэлцүүлж байгаа хүн нь холбоотой учраас би асууя гэж бодож байна. Юуны өмнө Зам, тээврийн сайдаас асуух гэсэн юм. Энэ өнөөдрийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны сүүлийн асуудал байж байгаа энэ цаглавар батлах тухай асуудал дээр орж ирээгүй учраас би бас тодруулъя гэж бодсон юм. Хоёрдугаарт энэ нэг асуудал бие биетэйгээ уялдаа холбоотой байгаа учраас.

Энэ ямар учиртай юм бэ гэхээр би таныг Зам, тээврийн сайдаар томилогдож байх үед Улсын Их Хурлын чуулган дээр танд анхаарлаа хандуулахыг хүсэж байсан нэг асуудал байгаа. Дараа нь 10 сард албан бичгээр хүсэлт тавьж уламжилсан. Энэ юу вэ гэхээр Монгол Улсын авто замыг хэвтээ тэнхлэгийн зүүн чиглэлд өөрөөр хэлбэл маш тодорхой хэлэх юм бол Өндөрхаан Чойбалсан хотын чиглэлийн хатуу хучилттай замын Цагаан хоолой гэдэг газрын 50 километр газар одоо болтол улсын комисс хүлээж аваагүй. Эвдрэл гэмтэл, гэмтэл бол дээд зэрэгтээ хүрсэн. Одоо энэ замаар зорчиж байгаа иргэдийн аюулгүй байдал амь нас, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал гээд яривал маш олон зүйлд сөрөг нөлөөлж байгаа ийм онцгой анхаарал татах ийм хэсэг байгаа юм. Тэгээд энэ 50 километр замын засварын ажлыг Дэлхийн банкны хүрээнд буюу Монгол Улсад хэрэгжүүлж байгаа төслүүдийн хүрээнд энэ 311 километр улсын чанартай авто замыг засна гэсэн ийм мэдээлэл би хараад байгаа юм.

Тэгээд энэ 311 километр замыг Дэлхийн банкны хөрөнгөөр засах энэ ажилд миний саяын хэлсэн энэ тамын тавь гэж нэрлэгддэг энэ зам орсон уу? Ороогүй бол энийг оруулах тал дээр та анхаарч өгөөч. Дээр нь энэ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор Дэлхийн банкны энэ асуудал бол орж ирэх нь ойлгомжтой. Хэзээ орж ирэх вэ ийм асуултыг асууя гэж бодож байна. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Хариулъя Бямбацогт сайд микрофоныг өгье.

С.Бямбацогт: Сэргэлэн гишүүний асуултад хариулъя. Ер нь эвдэрхий замаас болоод маш их зам, тээврийн осол гарч байгаа. Зам, тээврийн ослоос болж эд хөрөнгөөрөө, амь насаараа, эрүүл мэндээрээ маш олон иргэд хохирч байгаа. Зам яагаад эвдрээд байна вэ гэхээр

нэгдүгээрт нь бол замын даац хэтрүүлээд, ачаа тээвэр одоо ашиг орлох зорилгоор одоо ялангуяа уул уурхайн компаниуд даац хэтрүүлж зам эвддэг. Ашиг олох зорилгоор. Энд нь одоо иргэд хохирдог нэг ийм үндсэн шалтгаан. 2 дахь нэг шалтгаан бол замыг чанаргүй барьдаг. Ийм л 2 шалтгаанаас бол зам эвдэрч байгаа.

Чойбалсан Хэнтий чиглэлийн дундах одоо энэ зам бол тамын тавь гэж тэгвэл нэрлэдэг болчихсон. Тамын тавь гэж нэрлэгдэх хүртлээ одоо эвдэрчихсэн зам байна лээ. Энэ замыг бол арваад жилийн өмнө барьж байгуулсан. Барихад барьсан компани чанаргүй барьсан. Чанаргүй барьсан учраас Улсын комисс хүлээж аваагүй. Тухайн үедээ чанаргүй барьж байх үед нь одоо тухайн үед нь мэргэжлийн хяналтынхан мөн одоо бас замын хяналтын байцаагч нар уул нь тухайн үед нь шаардлага тавиад зогсоох ёстой байтал барьж дуустал нь явуулчихсан, бариад хаячихсан, мөнгөө авчихсан. Үүнээс болоод Зам, тээврийн хөгжлийн яам нэхэмжлэгчээр олон жил шүүхдээд энэ жил өнгөрсөн жил 22 онд шүүхийн шийдвэр гараад долоон тэрбум төгрөг л гүйцэтгэгч компаниас нь гаргуулахаар шийдсэн байна лээ. Энэ долоон тэрбум төгрөгийн одоо бол үндсэндээ бол шийдэгдсэн байгаа. Энэ одоо мөнгөөр зам засах нэг ийм хувилбар байж байгаа.

Гэтэл 50 километр зам бүхэлд нь засахад долоон тэрбум төгрөг хаана ч хүрэхгүй. Ийм учраас бид нар одоо бас өөр эх үүсвэр хайж байгаа. Өөр эх үүсвэр хайж байгаа энэ одоо бол нэг шийдэл нь бол энэ Дэлхийн банкны зуун сая долларын хөнгөлөлттэй зээлд хамруулах. Урьд нь яагаад орчхож болоогүй юм бэ гэхээр урьд нь бол үндсэндээ шүүх дээр маргаантай байсан учраас, улсын комисс хүлээж аваагүй зам учраас засах асуудал одоо эрх зүйн үндэс бүрдэхгүй байсан юм байна лээ. Одоо бол үндсэндээ ингээд шүүхийн шийдвэр гарчихсан, нэгэнтээ

засах нь тодорхой болчихсон учраас Дэлхийн банкны төсөл Дэлхийн банкныхантай бид нар бас харилцан ярилцаж уулзалт хийсэн. Дэлхийн банкны улс удирдлагуудтай. Энэ хүрээндээ бид нар одоо тэр Өвөрхангай аймагт баригдаж байгаа тэр махны логистикийн төвийг одоо барихаа больё. Энэ хэмнэгдсэн хөрөнгөөрөө бид нар энэ Дорнодын энэ 50 километр замын засварт зарцуулж болох юм гэдэг шийдэлд хүрээд, энэ шийдлийнхээ дагуу бичгээ би бас Сангийн яам руу ойрын үед одоо явуулж байгаа. Өнөөдөр явуулсан өөрөөр хэлэх юм бол.

Тэгээд одоо үндсэндээ Сангийн яаман дээр зөвшөөрөгдвөл энэ асуудал маань эргээд Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороогоор орж ирээд хэлэлцэгдээд, үндсэндээ Их Хуралд соёрхон батлагдаад явчихна. Ийм л одоо процесстэй явж байгаа. Энэ Дэлхийн банкны зуун сая доллар бол үндсэндээ бол ихэнх нь зам засвар байсан, ганцхан нэг логистикийн төв байсан. Үүн дээр бас гишүүд бас нэлээд тийм эсэргүүцэлтэй хандсан. Тийм учраас Аюулгүй байдлын байнгын хорооноос асуудлыг хойшлуулсан. Хойшлуулаад одоо үндсэндээ бидний бол Дэлхийн банк манай яамны харилцан ойлголцсон шийдэлд хүрч байгаа зүйл бол ийм байдлаар хүрч байгаа. Үүнийг Сангийн яам дэмжих юм бол эргээд Аюулгүй байдлын байнгын хороогоор орж ирээд, ингээд цаашаа явах бололцоотой байгаа гэдгийг танд хэлье.

Б.Энх-Амгалан: Сэргэлэн гишүүн тодруулъя 1 минут.

Ц.Сэргэлэн: Танд маш их баярлалаа. Би баярлаж байгаа асуудал биш, энэ бол ерөөсөө энэ замаар зорчдог бүх зорчигчид, дээр нь манай Дорнод нутгийн ард иргэдийн Улаанбаатар хоттой болон бусад аймаг орон нутагтай холбогддог гол зам, улсын чанартай зам. Энийг Зам, тээврийн хөгжлийн сайд энэ богино хугацаандаа анхааралдаа аваад,

ингээд Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд засахаар шийдвэрлэж, энэ асуудал үндсэндээ цаашидаа яригдаад ажил хэрэг болно гэж би итгэлээ. Тийм учраас энэ боломжийг ашиглаад би Дорнод нутгийнхаа зон олны өмнөөс танд баярлалаа гэдгээ хэлэх гэсэн юм. Тэгээд ажил хэргийг хурдан шуурхай явуулна гэдэгт итгэж байна. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Сэргэлэн гишүүн санал хэлчихлээ. Амартүвшин гишүүн асуултаа асууя. Амартүвшин гишүүний материалыг юу микрофоныг өгье.

Г.Амартүвшин: Баярлалаа. Би Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга байгаа болохоор би товч нэг асуулт асуучихъя. 22 онд Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр нисдэг дамжин өнгөрдөг нислэгүүдээс орлого олдог тийм ээ, тэр орлого маань хэд байсан бэ? Буурсан гэж мэдээлж байсан. Мэдээж хэрэг өнөө Оросын нутаг дэвсгэр дээгүүр гаднын онгоцнууд нисэхээ больсонтой холбоотой гэж ойлгосон. Энэ жилийн төлөв ямар байна вэ, товчхон мэдээлэл өгчих үү? Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Мөнхтуяа дарга асуултад хариулъя, 4 номерын микрофоныг өгье. Микроноо битгий дараарай, цаанаасаа өгөгдөнө, 4 номерын микрофоныг өгье.

Ч.Мөнхтуяа: 22 онд төлөвлөсөн орлогоосоо 115 тэрбумыг олсон, ер нь нийтдээ хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 47 тэрбумын алдагдалтай ажилласан. 150 тэрбумыг улсын төсөвт төвлөрүүлэх ёстой байсан боловч 16 тэрбумыг л төвлөрүүлж чадсан. Тэгээд бусад нь зардалтай явсан. Энэ онд ч гэсэн нэг үсэрч шальсан юм алга байна. Энэ оны хувьд оны эхний 2 сарын байдлаар өнгөрөлтийн нислэг болохоор юу олон улсын өнгөрөлт болохоор 12179 онгоц олон улсын өнгөрөлт. Энэ болохоор бидний төлөвлөснөөс 50 гаруй хувийн, ойролцоогоор 54 хувийн бууралттай гарч

ирсэн юм. Тэгээд орлого нь болохоор 33.7 сая төгрөг болчихоод байна.

Б.Энх-Амгалан: Бямбацогт сайд нэмж хариулъя.

С.Бямбацогт: Энэ Монгол Улсын дээгүүр агаараар агаарын орон зайгаар нисэж өнгөрч байгаа онгоцнуудын хураамж авдаг. Үүнээсээ Монгол улсад жилдээ нэг 300 орчим тэрбум төгрөгийн орлого олдог байсан бол одоо үндсэндээ 100-гаад тэрбум болж буурчихсан байгаа юм. Тэгээд алдагдалтай ажиллаж байгаа. Улсын төсөвт орлого оруулдаг байсан бол одоо улсын төсвөөс алдагдалтай болчихсон, орлогоо оруулж чадахаа. Үүнийг одоо ойлгохдоо бол үндсэндээ энэ Засгийн газар, Зам, тээврийн хөгжлийн яам, Иргэний нисэхийн ерөнхий газар муу ажиллаад одоо үүнээсээ болоод Монголчуудын нэр хүнд унаснаас Монгол Улсын дээгүүр нисэхээ больчихсон юм шиг тийм мушгисан ойлголт хүмүүс ярьдаг юм. Ийм зүйл бол байхгүй. Үндсэндээ ОХУ Украйнтай дайн хийсэн. Үүнээс болоод одоо дэлхий нийтийн хоригт орсон, хоригт орсноор Оросын дээгүүр онгоц нисэхээ болихоор Монгол Улс чинь үндсэндээ түүнд нь одоо хоморгод нь хэлмэгдээд л одоо үндсэндээ хохироод явж байгаа юм л даа. Орос дээгүүр Монгол дээгүүр нисээд ямар Оросыг алгасаад нисэхгүй шүү дээ. Ази Европыг холбосон Хойд Америк Азийг холбосон тийм үү хамгийн дөт зам Монгол улс дээгүүр байдаг. Монгол, Орос дээгүүр. Гэтэл ингээд нисэх гээд тэгэхээр зөвхөн Монгол дээгүүр нисээд Орос дээгүүр нисэхгүй байж болохгүй учраас Орос дээгүүр нисэхгүйн тулд Монгол дээгүүр нисэхээ больчихож байгаа юм. Үүнээсээ болоод орлого маань буурсан.

Тэгэхээр үндсэндээ бол Оросын байдал хэвийн байдалд орох хүртэл хугацаанд манай үндсэндээ агаарын навигацийн орлого бол ийм одоо бага байхаар л ийм байдал харагдаж байгаа.

Гэхдээ сүүлийн үед бол бага зэрэг нэмэгдэж байгаа, тийм. Хүмүүс бол мушгиад одоо юу гэдэг юм Монгол Улсын нэр хүнд муугаас болоод, Монгол улс буруу үйл ажиллагаа явуулснаас Монголыг тойрч одоо агаарын тээвэр онгоцнууд нисээд байгаа юм шиг тийм мушгисан ойлголтууд бас сошиал дээр явж байсан. Энэ бол шал худлаа шүү гэдгийг бас хэлчихье.

Б.Энх-Амгалан: Хариулт хангалттай тийм ээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү. Алга байна. Би нэг зүйлийг бас энд хэлье дээ. Энэ нэгэнт одоо манай дээр дамжин өнгөрч байгаа онгоцнуудын навигацийн орлогыг нэмэгдүүлэх асуудал дээр нэлээн анхаарч байгаа учраас Говь-Алтай аймгийн Цогт сумын нутгаар орж ирж байгаа агаарын хаалганы асуудлыг, Цээл сумын нутгаар орж ирэх агаарын хаалганы энэ асуудлыг нэлээн идэвхтэй сайн хөөцөлдөж, бас тэрүүгээр баруун бүсийн нэг агаарын хаалга нээх юм бол энэ навигацийн орлого нэмэгдэх бас Дундад Азиас нисэж байгаа онгоцнууд энэ манай улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжих ийм бололцоо боломж бүрдэх юм. Энэ дээр нэлээн анхаараарай.

Зүүн хойд хойшоогоо Хятадын Шинжаан Уйгураас Манжуур чиглэлд нисэж байгаа бас нислэг энүүгээр явах бас нэг бололцоо боломж давхар байгаа гэдгийг бас анхааралдаа авна биз. Мөн одоо энэ Иргэний нисэхийн МИАТ компанийн нислэгийг Хайнан Шанхай чиглэлд нисэх асуудлыг өмнө нь бас тавьж байсан. Тэгээд энэ асуудлууд дээр Хайнан зөвшөөрлийг өгсөн, Шанхай өгөөгүй байгаа гэсэн ийм мэдээлэл байдаг. Тийм учраас энэ дээр бас анхаараарай гэдгийг хэлье. Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулъя. Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн

томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд саналаа өгнө үү. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 75 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан танилцуулъя. Ажлын хэсэгт баярлалаа. Дараагийн асуудалд оръё. Дараагийн ажлын хэсгүүд хэсгийг оруулаарай.

14.52 цаг

Гурав.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг

Дараагийн асуудалдаа оръё. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцье. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Янгуугийн Содбаатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Очирсүхийн Машбат Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга, Алтангэрэлийн Бямбажаргал Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх ийм хүмүүсийн бүрэлдэхүүнтэй оролцож байна. Монгол Улсын

Ерөнхийлөгчийн хоригийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгуугийн Содбаатар танилцуулна. Содбаатар даргын микрофоныг өгье, 4 номерын микрофон.

Я.Содбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулиудыг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталж, Монгол Улсын Их Хурлын дарга 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 16 цаг 50 минутад ёсчлон, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01/126 дугаар тоот албан бичгээр ирүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн Нэгдүгээр хэсгийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар 8 дахь хэсгийг тус тус үндэслэн Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээллийн, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулиудад дараах үндэслэлээр бүхэлд нь хориг тавьж байна.

Нэг.Монгол Улсын Засгийн газар 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Олон нийтийн сүлжээнд хүний

эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд улсын даргад Монгол Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлснээс мэдүүлсэн бөгөөд Монгол Улсын Их Хурал уг хуулийн төслийг хэлэлцэж эхэлснээс хойш 2 өдөрт багтаан хэлэлцэн баталсан байна. Хуулийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах үйл явцад иргэн олон нийтийн оролцоог хангаагүй, эрх, хуулиас эрх, хууль, ёсны, ашиг сонирхол нь хөндөгдөх этгээд төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагаар хэлэлцүүлж саналыг нь аваагүй, Монгол Улсын аваагүй нь Монгол Улсын үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт иргэд бусад байгууллага хуулийн төслийн талаар тухайн саналаа хууль санаачлагчид уламжилна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.6 дахь заалт, 38 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ардчилсан ёс, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төр, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн хэмээх заалтыг зөрчих нөхцөлийг бий болгосон байна.

Монгол Улсын үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ мөн хариуцна хэмээн тодорхой заасан. Мөн Монгол Улсын үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт хүний эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ, хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй хэмээн Үндсэн хуулиар хязгаарлалт тогтоосныг анхаарч байх ёстой. Тиймээс хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа хууль

тогтоомжийг боловсруулах, хэлэлцэн батлахдаа олон нийтийн оролцоог сайтар хангаж, мэргэжлийн болон судалгааны байгууллагын санаа бодлыг сонсож, олон улсын сайн туршилага, судалгаа шинжилгээнд суурилан Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчмыг чанд баримталж байх учиртай.

Хоёр.Монгол Улсын үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн нэгд Улсын Их Хурлын баталсан хууль бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих хэмээн Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхэд заасан байдаг.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэгт энэ хуулийн 45.4-д заасны дагуу илгээсэн хууль тогтоолыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Монгол Улсын Ерөнхийлөгч тухайн хуулийн тогтоолыг бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ гэж заасан. Олон нийтийн сүлжээнд хүний эрх хамгаалах тухай болон түүнийг дагалдан батлагдсан нэр бүхий хуулиудын дагаж мөрдөх хугацаа 23 оны 2 дугаар сарын 1-ний өдөр байхаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох хэсгүүдийг зөрчиж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавих эрхийг хязгаарласан байна. Монгол Улсын Ерөнхийлөгч олон нийтийн сүлжээ цахим орчны талаарх эрх зүйн орчныг тодорхой боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байгаа болно. Монгол Улсын хувьд энэ хууль төдийгүй хууль тогтоомжийг батлан гаргахдаа эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээдийн этгээдүүдийн оролцоог хангах, эрдэмтэн судлаачид, мэргэжлийн холбоод, иргэдийн

саналыг авч сайтар хэлэлцэн хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлж, саналыг тусгаж, асуудалд тооцоо судалгаатай, шинжлэх ухаанч байр сууриас хандаж, олон улсын сайн туршилага, жишиг, жишиг стандартыг бүх талаас нь судлан, өөрийн орны давуу тал, онцлогийг тусган, хийгүй, чамбай хууль баталж гаргаж байх шаардлагатай гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчийн дээрх хуулиудад тавьсан хоригийг хууль тогтоомжид заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Б.Энх-Амгалан: Содбаатар даргад баярлалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. 3 асуулт асууя. Хоригтой холбогдуулаад сая Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга мэдээлэл хийлээ. Энэ дээр бол бас нэг одоо хууль санаачлагч нар болон хуулийн ажлын хэсгийнхэн нэг ийм тайлбар өгөөд байгаа. Энэ дээр нэг хууль зүйн хувьд Маашбат зөвлөхөөс, Маашбат даргаас, Бямбажаргал зөвлөх хоёроос л асууя даа. Энэ Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 21.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хууль, тогтоолын төслийг нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын даргын дарга өмнө нь баталсан хэлэлцэх асуудлын тов дараалалд өөрчлөлт оруулж, чуулганаар хэлэлцүүлэх тухай захирамж гаргана гэж заасан.

Хоёрдугаарт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.8-д хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 12.2-т заасан хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болно гэж заасан. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 12.2.17-д заасан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д заасан хууль тогтоомжийн төсөл, мөн 12.2.18-д заасан Үндэсний аюулгүй байдлын тухай хууль хуулийн 3.4.1, 3.4.3-д заасан асуудлаар боловсруулсан хууль тогтоомжийн төслүүд дээр олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болохоор заасан байна.

Дүгнэж үзвэл Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг хэлэлцүүлж, батлуулах явцад Хууль тогтоомжийн тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль зөрчигдсөн гэж одоо үзэхээргүй байна гэсэн ийм зүйлийг хууль одоо санаачлагч нар тайлбар ирүүлж байгаа. Энэ дээр нэг хуулийн тайлбар өгөөч гэж Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөхөөс хүсээд байгаа юм. Хэн нь хариулах вэ? Энэ дээр нэг хариулт өгөөдхөөч.

Хоёр дахь асуудал нь бол энэ хууль Засгийн газар дахин боловсруулж оруулж ирэх үү? Би Учрал сайдаас асуух гээд байна л даа. Энэ яагаад гэвэл цахим орчинд хүний эрхийг зөрчих асуудлаар явж байгаа их чухал асуудлууд энд байж байгаа юм. Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан 12 л асуудлыг энэ хуулиар зохицуулах гэж байгаа юм. Монгол Улсын төрийн бэлгэ тэмдгийг гутаан доромжилсон, цахим сүлжээ ашигласан залилан залилсан, залилахыг завдсан, хүүхдийн бие махбод, оюун санаа, зан суртахуунд сөргөөр нөлөөлөхүйц дарамт үзүүлсэн, уриалсан, сурталчилсан, хүчирхийлэл, садар самууныг уриалсан, сурталчилсан, хүнийг заналхийлэх, амиа хорлох, бие махбодод нь гэмтэл учруулах, учруулахыг уриалсан, сурталчилсан, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээг уриалсан, сурталчилсан, экстремист үйл ажиллагаа явуулах, үндэсний эв нэгдлийг бусниулах, төрийн болон албаны нууцыг задруулах, террорист үйлдэл хийх, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй

байдлын эсрэг гэмт хэргийн шинжийг агуулсан гэмт хэрэг үйлдэхэд өдөөн турхирсан, уриалсан, хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдлаар ялгаварлан гадуурхсан, оюуны өмчийн эрхийн зөрчилтэй, гэмт хэрэг зөрчилд тооцогдох үйлдлийг нарийвчлан зааварчилж эсвэл гэмт хэрэг зөрчил үйлдэхийг уриалсан, өдөөн турхирсан, хатгасан, сурталчилсан, дэмжсэн, хүүхдийг гуйлга гуйх, тэнэмэл, хараа хяналтгүй амьдралд татан оруулсан, уриалсан, өдөөн хатгасан, сурталчилсан гэх мэт ийм 12 зүйлийг хуульд зохицуулахаар хуульчилсан.

Тэгээд энэ хуулиуд энэ хуультай холбоотойгоор Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авбал хууль дахин боловсруулагдах уу, хэзээ орж ирэх вэ гэдэг ийм асуудлыг Учрал сайдаас асууя. Эхлээд Содбаатар дарга хариулъя. 4 номерын микрофон.

Я.Содбаатар: Би хариулъя. Ерөнхийдөө бол Монгол Улсын Ерөнхийлөгч олон нийтийн сүлжээнд Олон нийтийн сүлжээнд хүний эрх хамгаалах тухай хууль холбогдох гэж байгаа хуулиудад бүхэлд нь хориг тавьж байгаа. Яагаад энэ хориг тавьж байгаа юм гэхээр бид нар бол энэ хориг тавихдаа цахим орчинд үүсээд байгаа нөхцөл байдал хүчирхийлэлд уриалж байгаа, залилах гэмт хэрэг ихсэж байгаа, цахим орчинд үүсэж байгаа гэмт хэргийн тоо жилээс жилд 2-3 дахин өсөж байгаа эд нар энэ бүгдийг бол бид нар үгүйсгээгүй.

Нэг ёсны Монгол Улсын энэ олон нийтийн сүлжээ цахим орчинд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зайлиггүй шаардлага байгаа гэж бас үзэж байгаа юм. Улсын Их Хурал Олон нийтийн сүлжээнд хүний эрх хамгаалах тухай хууль, холбогдох хуулиудыг хэлэлцэн батлахдаа Үндсэн хууль, Улсын Их

Хурлын хуралдааны дэгийн тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна гэж үзэж хориг тавьсан. Улсын Их Хурлыг энэ хуулийг хэлэлцэж байх явцад зарим гишүүд ч гэсэн Байнгын хороон дээр, чуулган дээр ийм яаралтай горимоор Улсын Их Хурлын явж ирдэг дэгуудийг зөрчиж, ингэж хууль баталж болох юм уу гэдгийг ч ярьж байсныг та бүхэн санаж байгаа байх.

Тийм учраас Улсын Их Хурал аливаа хууль тогтоомж батлахдаа зөвхөн энэ хууль тогтоомж төдийгүй аливаа хууль тогтоомж батлахдаа эрх нь хөндөгдөж байгаа талуудын саналыг авах. Энэ бол таны хэлээд байгаа тэр олон нийтийн хэлэлцүүлэг гэхээсээ илүү энэ хуулиар эрх нь хөндөгдөх хуулийн этгээдүүдийн асуудал яригдаж хөндөгдөж байгаа. Мөн эрдэмтэн судлаачид, гадна дотнын жишиг юунуудыг авч хууль баталж байх нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Ийм учраас Монгол Улсын Ерөнхийлөгч энэ хуулийг батлахад энэ олон талын саналыг авах эрдэмтэн судлаачдын саналыг авах, нийгмийн хэлэлцүүлэг тодорхой хэмжээгээр явуулах асуудлуудыг зөрчигдсөн байна гээд холбогдох хуулийн заалтуудыг яаж байгааг би гишүүд ойлгон хүлээж авах байх гэж ингэж бодож байна.

Цахим орчныг цаашидаа эрх зүйн орчныг тодорхой болгох зайлшгүй боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байгаа гэдэг байр суурьтай байгаа. Засгийн газар ч ийм байр суурьтай байгаа байх гэж бодож байна. Улсын Их Хурал ч энд анхаарах хэрэгтэй.

Миний дараа бол Учрал сайд харин дэгээр хариулж болохгүй. Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 88 дээр бол Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэхэд хууль санаачилсан тэр өмнөх нөгөө хуулиа яасан хүн хариулт өгч болдоггүй. Тийм учраас бас та дэг

зөрчихгүйн үүднээс энэ дүрмийг барих ёстой гэдгийг бас танд сануулъя.

Б.Энх-Амгалан: Дэгийн хуулиар бол өргөн барьсан хүн хариулах аргагүй ийм заалттай учраас Засгийн газарт энийг бол ямар ч байсан дахин өргөн барих асуудлыг бол Ерөнхийлөгчийн Тамгын газар бол зөв зүйтэй гэж үзэж байгаа юм байна тийм ээ? Нэг ёсондоо хариултаа авчихлаа гэж ойлголоо. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ерөнхийлөгчийн хоригтой холбоотойгоор үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Гишүүд үг хэлж дууслаа. Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулаад одоо энэ асуудалтай холбогдуулаад санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хувийн нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд саналаа өгнө үү. Санал хураалт. Санал хураалтад 11 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 81.8 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд миний бие танилцуулна. Ажлын хэсэгт баярлалаа.

15.09 цаг

**Дөрөв.Байнгын хорооны тогтоолын
төсөл /Улсын Их Хурлын 2023 оны**

*хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард
Аюулгүй байдал, гадаад бодлогын
байнгын хорооны хэлэлцэх асуудлын
цаглавар батлах тухай/*

*Дараагийн асуудалдаа орёё.
Монгол Улсын Их Хурлын 2023 оны
хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард
Аюулгүй байдал, гадаад бодлогын
байнгын хорооны хэлэлцэх асуудлын
цаглавар батлах тухай Байнгын хорооны
тогтоолын төслийг хэлэлцье. Монгол
Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Их
Хурлын 2023 оны хаврын ээлжит
чуулганы 3 дугаар сард хэлэлцэх асуудлын
дараалал тогтоох тухай 49 дүгээр
захирамжийг 2023 оны 3 дугаар сарын 14-
ний өдөр баталсан байна.*

*Байнгын хорооны тогтоолын
төслийг та бүхэнд тараасан байгаа.
Тогтоолын төсөлтэй холбогдуулан
асуулт асуух гишүүн байна уу? Алга
байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулж
холбогдуулан гишүүд асуулт асууж,
хариулт авч дууслаа. Тогтоолын
төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд
нэрээ өгнө үү. Алга байна, үг хэлж
дууслаа. Монгол Улсын Их Хурлын 2023
оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар
сард Аюулгүй байдал, гадаад бодлогын
байнгын хорооны хэлэлцэх асуудлын
цаглавар батлах тухай тогтоолын
төслийг баталъя гэсэн томъёоллоор
санал хураалт явуулъя. Санал хураалт
гишүүдээ. Наранбаатар гишүүн саналаа
өгөөрэй, Баделхан гишүүнээ саналаа
өгөөрэй. Баделхан гишүүнээ саналаа
өгөөрэй. Санал хураалтад 11 гишүүн
оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн
саналаар уг санал дэмжигдлээ.
Наранбаатар гишүүний төхөөрөмж
ажиллаагүй учраас протоколд
дэмжсэнээр тэмдэглэе.*

15.11 цаг

*Байнгын хорооны хуралдаанаар
хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн
хуралдааныг хаасныг мэдэгдье.*

*Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их
Хурлын гишүүддээ баярлалаа. Өнөөдрийн
хуралдаан өндөрлөлөө.*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА*